

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02-р сарын 13-ны өдөр

№ 26/08

Улаанбаатар хот

Энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, “Инвекор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.21 дэх заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 8,701,402,980 (Найман тэрбум долоон зуун нэг сая дөрвөн зуун хоёр мянга есөн зуун ная) төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилсугай;
2. Компанийн нэгж энгийн хувьцаанд олгох ногдол ашгийг 114.9 (Нэг зуун арван дөрвөн төгрөг есөн мөнгө) төгрөгөөр тогтоосугай;
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай;
4. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК- аар дамжуулан 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд олгосугай;
5. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Оролмаа/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

